



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Эмч, эмнэлгийн ажилтныг
урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд
хамруулах журам


Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Заавар батлах тухай” А/537 дугаар тушаал, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.4.1. дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн засах төвийн эмч, эмнэлгийн ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг нэгдүгээр, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллахыг эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмч /Н.Эрдэнэчимэг/-д, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эмчилгээний тасгийн эрхлэгч, халдвар хяналтын багийн ахлагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Б.Уянга/ нарт даалгасугай.

ДАРГА *Ш.Саруултуяа* Ш.САРУУЛТУЯА



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 03 сарын 01 өдрийн
... дугаар тушаалын ... хавсралт
A/107



ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫГУРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНДХАМРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Сэргээн төвд ажиллаж байгаа болон шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино,
- 1.2 Хүний эрхийг дээдлэн ажилтны эрүүл мэндийн байдлын талаар хувь хүний нууцыг чандлан хадгална.
- 1.3 Эмч, эмнэлгийн ажилтны жил бүрийн үзлэг шинжилгээ, дархлаажуулалтын зардлыг сэргээн засах төв, шинээр ажилд орж байгаа эмч, эмнэлгийн ажилтны үзлэг шинжилгээтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.
- 1.4 Жил бүрийн 2 удаа Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран Хүний нөөцөөс гаргасан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хуваарийн дагуу эмч, эмнэлгийн ажилтныг бүрэн хамруулахыг тасгийн эрхлэгч нар хариуцан ажиллана.
- 1.5 Шинээр ажилд орж буй эмч, эмнэлгийн ажилтан ажлын 5 хоногт багтаан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдана.
- 1.6 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүгнэлт, оношийн дагуу холбогдох нарийн мэргэжлийн эмч нар хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний дагуу эмчилж, эрүүлжүүлэлтийн хувийг тооцон ажиллана.

ХОЁР. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ

- 2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх тушаал, журам, зааврыг мөрдөж ажиллана.
- 2.2 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хуваарийн дагуу орж, хориглох заалтгүй бол эмч, эмнэлгийн ажилтны хамрагдах шаардлагатай дархлаажуулалтад хамрагдана.
- 2.3 Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдана.
- 2.4 Үйлчлүүлэгч болон бусдад халдвар тараах эрсдэл үүссэн үед халдварын

сэргийлэлт, хяналтын баг, эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчид мэдэгдэнэ.

**ГУРАВ. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНД
ХАРИУЦСАН ЭМЧИЙН ҮҮРЭГ**

- 3.1. Эмч, эмнэлгийн ажилтны урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүгнэлт, онош, эмчлэгдэж эрүүлжсэн, дархлаажуулалтад хамрагдсан тухай бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэж, тайлагнана.
- 3.2. Эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн ажиллана.
- 3.3. Шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг төлөвлөн ажиллана.
- 3.4. Эмч, эмнэлгийн ажилчдад дотрын эмчийн үзлэг хийн, эмчлэн эрүүлжүүлнэ.

**ДӨРӨВ. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ,
ДАРХЛААЖУУЛАЛТ**

- 4.1 Эмч, эмнэлгийн ажилтныг жил бүр дараах үзлэг, шинжилгээнд хамруулна.
 - 4.1.1 Сүрьеэ өвчин илрүүлэх
 - 4.1.2 Гепатитийн В, С вирус илрүүлэх
 - 4.1.3 ХДХВ -ийн халдвар илрүүлэх
 - 4.1.4 Гепатитийн В вирусийн дархлаажуулалтад хамрагдаагүй ажилтанг В вирус илрүүлэх шинжилгээнд хамруулах
 - 4.1.5 Гепатитийн В вирусийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтанг 5 жил тутамд 1 удаа дархлал тогтцын шинжилгээнд хамруулах
 - 4.1.6 Гепатитийн В вирусийн архаг халдвартай бол D вирус илрүүлэх
 - 4.1.7 Гепатитийн В, С вирусийн архаг халдвартай, эмчилгээнд хамрагдаагүй бол вирусийн идэвхжил тодорхойлох
 - 4.1.8 Цагаан хорхой илрүүлэх шинжилгээнд хамруулах
 - 4.1.9 Хэвлийн хэт авиан шинжилгээ
 - 4.1.10 Цусны ерөнхий шинжилгээ
 - 4.1.11 Шээсний ерөнхий шинжилгээ
 - 4.1.12 Биохимийн шинжилгээ
 - 4.1.13 Дотрын эмчийн үзлэг /эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн үзлэг/
 - 4.1.14 Шаардлагатай шинжилгээ, үзлэгт эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн заалтаар хамрагдана.

- 4.2 Шинээр ажилд орж буй эмч, эмнэлгийн ажилтан дараах үзлэг, шинжилгээнд хамрагдаж, дархлаажуулалтын мэдээллийг өгнө.
- 4.2.1 Сүрьеэ өвчин илрүүлэх
- 4.2.2 Гепатитийн В, С вирус илрүүлэх
- 4.2.3 В гепатитийн вакцинд хамрагдсан бол дархлал тогтцын шинжилгээний дүнг, дархлаажуулалтад хамрагдсан ч дархлал тогтцын шинжилгээ хийлгээгүй бол шинжилгээнд хамруулж дүнг хувийн хэрэгт хавсаргана.
- 4.2.4 ХДХВ-ийн халдвар илрүүлэх
- 4.2.5 Улаанбурхан, гахай хавдар, улаануудын дархлаажуулалтад хамрагдсан эсэх хамрагдсан бол хугацааг асуумжаар тодруулах, эсрэг бие тодорхойлох шинжилгээнд хамруулна.
- 4.2.6 Улаанбурхан, салхин цэцгийн халдвараар өвдсөн эсэхийг асуумжаар тодруулж үзлэгийн хуудаст тэмдэглэнэ.
- 4.2.7 Цагаан хорхой илрүүлэх шинжилгээнд хамруулах
- 4.3 Эмч, эмнэлгийн ажилтан нь гепатит В вирус, улаанбурхан, улаанууд, гахайн хавдар, сахуу татран, хөхүүл ханиад, татран, томуу зэрэг өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байна.
- 4.3.1 Гепатит В вирусийн вакцинд хамруулахдаа В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg) илрүүлэх шинжилгээнд хамруулна.
- 4.3.2 Гадаргуугийн эсрэгтөрөгч сөрөг үед Anti-HBs, Anti-HBc маркерийг тодорхойлох шинжилгээнд хамруулж шинжилгээний дүн сөрөг бол гепатитийн В вирусийн эсрэг вакцинаар 3 тунгаар дархлаажуулна. Эхний тунгаас 2 дахь тунг 1 сарын зайтай, 3 дахь тунг 2 дахь тунгаас 5 сарын зайтай хийнэ.
- 4.3.3 Жил бүр томуугийн дархлаажуулалтад хамрагдана. Томуугийн вакцины зааврыг баримтлан хийнэ.
- 4.3.4 Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакциныг тухайн халдвараар өвдөөгүй, дархлаагүй ажилтанг 2 тунгаар дархлаажуулна. Эхний тунгаас 1 сарын зайтай 2 дахь тунг хийнэ.
- 4.3.5 Сахуу, татран, хөхүүл ханиадны халдварын эрсдэлд үнэлгээ хийж эмнэлгийн ажилтанг дархлаажуулна.
- 4.4 Дархлаажуулалтад хамрагдсан бол эсрэг бие тогтсон эсэхийг баталгаажуулж, эрүүл мэндийн хуудсанд тэмдэглэн, хувийн хэрэгт хавсаргана.
- 4.4.1 В гепатитийн эсрэг вакцины дархлаа тогтцыг сүүлийн тунгаас 1 сараас хойш

хугацаанд тодорхойлно. Anti-HBs маркер 10мл/IU -ээс их бол дархлал тогтсон гэж үзнэ.

4.4.2 Anti-HBs маркер 10мл/IU -ээс бага бол В гепатитийн эсрэг вакцинаар дахин 3 тунгаар, Anti-HBs маркер 100мл/IU -ээс бага тогтсон бол дахин 1 тунгаар дархлаажуулна.

4.4.3 Anti-HBs маркер 100мл/IU -ээс их дархлаа тогтсон бол 5 жилийн дараа дархлаа тогтцын шинжилгээг давтан тодорхойлуулна. 5 жил дотор дахин дархлал тогтоц үзэх шаардлагагүй.

4.4.4 Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын өвөрмөц IgG үзэж дархлаатай эсэхийг баталгаажуулна.

4.4.5 Гэдэсний балнад, тарваган тахал, сүрьеэгийн эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар болон сайн дурын хэлбэрээр дархлаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

ТАВ. ЦУСААР ДАМЖИХ ХАЛДВАРТАЙ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТАНД ТАВИХ ХЯНАЛТ

- 5.1. Гепатитийн архаг халдвартай эрүүл мэндийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхжилийг жилд 1 удаа хийлгэнэ.
- 5.2. Эмч, эмнэлгийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхжил $>10^4$ GE/ml тохиолдолд мэс ажилбарт оролцуулахыг хязгаарлах арга хэмжээ авна.
- 5.3. Эмч, эмнэлгийн ажилтанд ХДХВ-ийн халдвар илэрсэн тохиолдолд мэс ажилбар, шүд, эх барих, чих хамар хоолой гэх мэт ажилбар бүхий тусламж үйлчилгээг хийлгэхгүй.

ЗУРГАА. ЦУСААР ДАМЖИХ ХАЛДВАРТАЙ БОЛОХ НЬ ТОГТООГДСОН ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТАНТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНД ДАРААХ АСУУДЛЫГ ТУСГАХ

- 6.1. Эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийг хариуцсан эмчийн хяналтад байж жил бүр вирусийн идэвхжилийг шинжилгээгээр хянах, өвчний явц, эмчилгээний талаар зөвлөгөө авах
- 6.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх асуудлаар сургалтад хамрагдах, халдвараас сэргийлэх заавар журмыг чанд мөрдөж ажиллах
- 6.3. Ажлын байр өөрчлөгдөх, вирус идэвхжсэн, өөр төрлийн өвчин эмгэг илрэх зэрэг үйлчлүүлэгчид халдвар дамжуулах эрсдэлтэй тохиолдолд эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчид мэдэгдэх

6.4. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч халдварт өртөх эрсдэл үүссэн тохиолдлыг нэн даруй эмч, эмнэлгийн ажилтан хариуцсан эмч эмч, тархвар судлаачид мэдэгдэх

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 03 сарын 01 өдрийн
А/а дугаар тушаалын 2 хавсралт

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУДАС

1. Овог

2. Нэр

3. Нас _

4. Хүйс: ☐ Эр ☐ Эм

5. Албан тушаал:

А. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ /Жил бүр эмч, эмнэлгийн ажилтан
хамрагдана/

Үзлэг, шинжилгээний төрөл	Үр дүн	Он сар өдөр	Эмнэлэг, лабораторийн нэр	Эмчийн гарын үсэг тамга
Цээж гэрэлд харах				
ХДХВ				
HBsAg				
Anti HBs				
Anti HCV				
Хэвлийн ЭХО				
Биохими				
ЦЕШ				
ШЕШ				
Цагаан хорхой				
Дотор /Эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмч/				
Бусад шаардлагатай шинжилгээ, үзлэг				

Б. Дархлаажуулалт

Баталгаажуулах	Дархлаажуулалтад хамрагдсан хугацаа он, тун	Эсрэг бие тодорхойлуулсан эсэх Тийм/ Үгүй
Гепатит В: ☐ Тийм ☐ Үгүй Мэдэхгүй		
Сахуу, хөхүүл ханиад, татран: ☐ Тийм ☐ Үгүй Мэдэхгүй		
Улаанбурхан, гахай хавдар, улаанууд: ☐ Тийм ☐ Үгүй Мэдэхгүй		

В. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн дүгнэлт:

Эмчийн нэр

Гарын үсэг

Тамга

оны сар өдөр

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 03 сарын 01 өдрийн
А/07 дугаар тушаалын 3 хавсралт

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУДАС

1. Овог

2. Нэр

3. Нас

4. Хүйс: ☐ Эр ☐ Эм

5. Албан тушаал:

А. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ /Шинээр ажилд орж буй эмч, эмнэлгийн ажилтан хамрагдана/

Үзлэг, шинжилгээний төрөл	Үр дүн	Он сар өдөр	Эмнэлэг, лабораторийн нэр	Эмчийн гарын үсэг тамга
Цээж гэрэлд харах				
ХДХВ				
HBsAg				
Anti HBs				
Anti HCV				
Цагаан хорхой				

Б. Дархлаажуулалт

Баталгаажуулах	Дархлаажуулалтад хамрагдсан хугацаа он, тун	Эсрэг бие тодорхойлуулсан эсэх Тийм/ Үгүй
Гепатит В: ☐ Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй		
Сахуу, хөхүүл ханиад, татран: ☐ Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй		
Улаанбурхан, гахай хавдар, улаанууд: ☐ Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй		

В. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн дүгнэлт:

Эмчийн нэр

Гарын үсэг

Тамга

оны сар өдөр